ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 01 өдөр Дугаар А/78 Бор-Өндөр сум

## Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4-р зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн 1 иргэний өмчлөх эрх шилжүүлэх гэрээг харгалзан үзэж дундын өмчлөлийн газрыг үнэ төлбөргүйгээр гэр бүлийн бусад гишүүдэд шилжүүлэн 1-р хавсралтаар өмчлүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хоёрдугаар хавсралтад дурдсан, өмчлөх эрхээ сэргээж байгаа 2 иргэнд урьд өмнө гарсан газар өмчлүүлсэн захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцож, хоёрдугаар хавсралтаар мэдээллийг дурдсугай.

3.Газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээгээр эрхээ шилжүүлсэн иргэнд хууль тогтоомжид заасны дагуу газраа үнэ төлбөргүй өмчлөх эрхтэй болохыг зөвлөсүгэй.

4.Газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2026 оны 04 -р сарын 01 -ны өдрийн A/78 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

Өмчлөх эрх шилжүүлэн авагч болон газрын мэдээлэл

| № | Өмчлөх эрх шилжүүлэн авагчийн | | | | Газрын | | Нэгж талбарын дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистр | Байршил | Хэмжээ /м²/ | |
| 1 | Туваан | Лувсаншарав | Отгон | ЛЮ46050114 | 4-р баг Уурхайчин, Геологи-8 гудамж, 811 тоот | 687 | 2322003961 |

Сумын Засаг даргын 2026 оны 04-р сарын
01-ны өдрийн А/78 тоот захирамжийн
хоёрдугаар хавсралт

Өмчлөх эрхээ сэргээж байгаа иргэдийн мэдээлэл

| № | Хамтран өмчлөлөөс хасагдагч иргэний | | | | Захирамж |
|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистр | |
| 1 | Чулуухай | Чулуун | Жамбалсүрэн | ЛЮ52041500 | 2008.04.08 №49 |
| 2 | Туваан | Отгон | Батбаяр | ЛЮ81050311 | |